



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД
НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦОО



Судалгааг хянасан:

Н.Жамъянхүү

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Судалгааны багийн бусад гишүүд:

Х.Буянбат

М.Энхжин

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Захирал (LL.M)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ахлах
ажилтан (LL.M)

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан
(M.A)



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
I. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	6
1.1 Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох.....	9
1.2 Хүний нөөцийг тодорхойлох.....	13
1.3 Гарах зардлыг урьдчилан тооцох.....	19
1.4 Үр дүнг тооцох.....	25
1.5 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	26
ДҮГНЭЛТ, САНАЛ	28



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт.....	6
Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь.....	10
Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаатай холбоотой хүний нөөцийн хэрэгцээ.....	13
Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал.....	17
Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал.....	19
Хүснэгт 6. Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн хүнд үзүүлэх сургалтын зардал, багаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон шаардлагатай байгаа орон тооны судалгаа.....	21
Хүснэгт 7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторид шаардлагатай бүтэц орон тоо, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн зардал.....	24
Хүснэгт 8. Төрийн захиргааны байгууллагаас гарах нийт зардал.....	25

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.1.9-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”¹ хэмээн заасан.

Мөн түүнчлэн улсын хэмжээнд 2017-2025 онд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой нийт 2100 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнд 2422 хүн холбогдсон байх ба үүний 4.4 хувийг 13-17 насны, 50.4 хувийг 18-25 насны, 35.8 хувийг 26-35 насны, 9.2 хувийг 36-аас дээш насны хүн тус тус эзэлж байна. Ийнхүү Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэмт хэргийн нөхцөл байдал, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисын хууль ёсны эргэлтийг тодорхой зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй байдалтай холбоотойгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт тусгаснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д дурдсаны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй гарах зардал, нөлөөллийг эрх зүйн зохицуулалтад хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардал тус бүрээр тооцон судалсан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг тооцохдоо одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулиас шинэчлэгдсэн зохицуулалт агуулсан зүйл заалтуудыг сонгон судалсан болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн төсөлд хэвээр туссан, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй зүйл заалтыг одоогийн батлагдсан орон тоо, төсөв, зардалд нөлөөлөхгүй гэж үзлээ. Мөн түүнчлэн, санхүүжилтийг шийдвэрлэх тухай төрийн байгууллагат үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг урьдчилан тооцоолох боломжгүй гэж үзсэн болно.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

I. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гаргах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад тусгагдсан төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна. Үүнд:

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл, заалт
42 дугаар зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал устгах 42.1.Байгалийн болон тарималжуулсан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг нэн даруй, эсхүл үрлэхээс нь өмнө устгах арга хэмжээг энэ хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.	2.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар тариалангийн бүс нутгаас бусад газарт тархан ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтран холбогдох удирдамж, заавар, зөвлөмж, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.
45 дугаар зүйл.Үндэсний хороо, түүний бүрэн эрх 45.1.Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний хороо ажиллана.	45.5.Үндэсний хорооны үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
45.8.Үндэсний хороо мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	45.8.8.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээтэй тэмцэх, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах;
46 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 46.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	46.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагыг дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

48 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 48.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	48.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах, 33 тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;
49 дүгээр зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 49.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	49.1.3.сэтгэц-нийгмийн сэргээн засах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээ авах:
51 дүгээр зүйл.Тагнуулын байгууллагын чиг үүрэг 51.1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тагнуулын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	51.1.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;
52 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын чиг үүрэг 52.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар цагдаагийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	52.2.Цагдаагийн байгууллага дэргэдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг судлан тогтоох, тодорхойлох, шинжилгээ хийх лабораторитой байна.
53 дугаар зүйл.Хил хамгаалах байгууллагын чиг үүрэг 53.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хил хамгаалах байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	53.1.3. 53.1.3.хил орчмын нутаг дэвсгэрт тогтоогдсон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг эрх бүхий байгууллагатай хамтран устгах арга хэмжээ авах;
54 дүгээр зүйл.Гаалийн байгууллагын чиг үүрэг 54.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар гаалийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	54.1.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвшөөрөл, холбогдох баримт бичигтэй тулган шалгах, бүртгэх, газар дээр нь дээж авч, шинжилгээнд хамруулах; 54.1.4.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг олж илрүүлэх, таньж мэдэх зориулалт бүхий орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулах;
56 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг 56.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	51.1.3.алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах; 51.1.4.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих;

57 дугаар зүйл.Нутгийн удирдлагын байгууллагын чиг үүрэг 57.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн удирдлагын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	57.1.4.харьяа нутаг дэвсгэр дэх мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын тархцыг тогтоох, устгах үйл ажиллагааг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулах, тус арга хэмжээнд шаардагдах төсвийг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгах, санхүүжүүлэх;
59 дүгээр зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх 59.1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисоос хамааралтай хүнд төрөөс тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	59.6.Энэ хуулийн 59.2.1-д заасан тусламж, үйлчилгээг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллага үзүүлэх ба түүнд шаардагдах эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ. 59.7.Энэ хуулийн 59.2.2-т заасан тусламж, үйлчилгээг энэ хуульд заасан Донтох эмгэгийг нөхөн сэргээх төвөөс зохион байгуулж үзүүлэх ба түүнд шаардагдах зардлыг Үндэсний хороо болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.
62 дугаар зүйл.Донтох эмгэгийг нөхөн сэргээх төв	62.3.1-62.3.14
63 дугаар зүйл.Албадан эмчилгээ	63.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ хуулийн 61.4-т заасан албадлагын арга хэмжээнд энэ хуулийн 61.3, 62 дугаар зүйлд заасан байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтарч болно.
64 дүгээр зүйл.Нийгмийн хамгааллын арга хэмжээ	64.2.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих, амьдралын зөв дадал, хэвшил суулгах зорилгоор сургалтад хамруулах; 64.2.4.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
65 дугаар зүйл.Зан үйлд нөлөөлөх сургалт	65.2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байхад чиглэсэн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3, 62 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

1.1 Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийн 62 дугаар зүйл.Донтох эмгэгийн нөхөн сэргээх зүйлийн 62.3.-т “Донтох эмгэгийг нөхөн сэргээх үндэсний төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:” гэж заасан. Тус заалтын хүрээнд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, үйл ажиллагааг нэмэлтээр дараах байдлаар тусгажээ. Үүнд:

1. 62.3.1.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх;
2. 62.3.2.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас урьдчилан сэргийлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд донтох эмгэгийг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, хэрэглэсэн хүнд сургалт хийх хөтөлбөр, аргачлал, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
3. 62.3.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээллийн арга хэмжээг холбогдох чиг үүргийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
4. 62.3.4.сэтгэц-нийгмийн сэргээн засах чиглэлээр хүний нөөцийг сургаж, чадавхжуулах аргачлалыг боловсруулж, Үндэсний хороогоор батлуулах;
5. 62.3.5.хүн ам дахь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний тандалт, судалгааг зохион байгуулахад оролцох;
6. 62.3.6.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд донтох эмгэгийг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, хэрэглэсэн хүнд сургалт хийх, хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
7. 62.3.7.гадаад болон олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, сайн туршлагыг судалж нэвтрүүлэх, мэргэжилтэн солилцох;

8. 62.3.8.донтох эмгэгийг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах хүний нөөцийг сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;
9. 62.3.9.донтох эмгэгийг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх сургалтыг гэрээний үндсэн дээр энэ хуулийн 61.3-т заасан байгууллагаар гүйцэтгүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
10. 62.3.10.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай болон хэрэглэсэн хүнийг эмнэлгийн болон сэтгэл зүйн оношилгоонд хамруулах;
11. 62.3.11.гэр бүлийн зөвлөгөө өгөх, гэр бүл, хамт олныг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах;
12. 62.3.12.нийгэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, хөдөлмөрийн дадал олгох сургалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрийн дагуу явуулах;
13. 62.3.13.дахин мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий байдалд орохоос урьдчилан сэргийлэх хяналт, зөвлөгөө үзүүлэх;
14. 62.3.14.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарлаас эдгэрэл сайжрал авсан, хорт бодисын хамаарал бүхий байдлаа даван туулсан эсэхэд дүгнэлт гаргах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг нь тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо хэт нарийвчлахгүйгээр ерөнхий байдлаар бүлэглэх зарчмыг баримтлав.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	42.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар тариалангийн бүс нутгаас бусад газарт тархан ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтран холбогдох удирдамж, заавар, зөвлөмж, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.	-Устгалын ажил хийх
Үндэсний хороо	45.8.8.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээтэй тэмцэх, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах;	-Сургалт зохион байгуулах

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	46.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагыг дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;	-Тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	48.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;	-Үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт тодорхойлох
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	49.1.3.сэтгэц-нийгмийн сэргээн засах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээ авах;	-Мэргэжилтэн бэлтгэх
Тагнуулын байгууллага	51.1.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;	-Орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах
Цагдаагийн байгууллага	52.2.Цагдаагийн байгууллага дэргэдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг судлан тогтоох, тодорхойлох, шинжилгээ хийх лабораторитой байна. 67.2.Энэ хуулийн 67.1.1, 67.1.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг цагдаагийн төв байгууллага хариуцаж, хяналт тавина. 67.3.Энэ хуулийн 67.1.3-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг Донтох эмгэгийг нөхөн сэргээх төв хариуцаж, хяналт тавина.	-Шинжилгээ хийх лаборатори бий болгох
Хил хамгаалах байгууллага	53.1.3.хил орчмын нутаг дэвсгэрт тогтоогдсон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг эрх бүхий байгууллагатай хамтран устгах арга хэмжээ авах;	-Устгах арга хэмжээ авах
Гаалийн байгууллага	54.1.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг	-Шинжилгээнд хамруулах; -Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл

	зөвшөөрөл, холбогдох баримт бичигтэй тулган шалгах, бүртгэх, газар дээр нь дээж авч, шинжилгээнд хамруулах; 54.1.4.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг олж илрүүлэх, таньж мэдэх зориулалт бүхий орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулах;	ажиллагаандаа нэвтрүүлэх ашиглах; -Алба хаагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах тогтмол сургалт зохион байгуулах
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	51.1.3.алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;	-Алба хаагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах тогтмол сургалт зохион байгуулах; -Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ашиглах;
Аймаг нийслэл дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага	64.2.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих, амьдралын зөв дадал, хэвшил суулгах зорилгоор сургалтад хамруулах; 64.2.4.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;	-Сургалт зохион байгуулах
Донтох нийгмийн сэргээн засах төв	65.2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байхад чиглэсэн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3, 62 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.	-Сургалт зохион байгуулах

1.2 Хүний нөөцийг тодорхойлох

Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог (цаашид “тохиолдлын тоо” гэх), шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаатай холбоотой хүний нөөцийн хэрэгцээ

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ (мин)
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	42.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар тариалангийн бүс нутгаас бусад газарт тархан ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг цагдаа, байгаль орчин, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага, нутгийн удирдлагын байгууллагатай хамтран холбогдох удирдамж, заавар, зөвлөмж, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.	Устгалын ажил хийх	24000	1	24000
Үндэсний хороо	45.8.8.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээтэй тэмцэх, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах;	Сургалт зохион байгуулах	24000	4	96000

Гаалийн байгууллага	54.1.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвшөөрөл, холбогдох баримт бичигтэй тулган шалгах, бүртгэх, газар дээр нь дээж авч, шинжилгээнд хамруулах; 54.1.4.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг олж илрүүлэх, таньж мэдэх зориулалт бүхий орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулах;	Сургалт зохион байгуулах	24000	4	96000
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	51.1.3.алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;	Сургалт зохион байгуулах	24000	4	96000
Аймаг нийслэл дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага	64.2.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих, амьдралын зөв дадал, хэвшил суулгах зорилгоор сургалтад хамруулах;	Сургалт зохион байгуулах	24000	4	96000
Донтох нийгмийн сэргээн засах төв	65.2.Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байхад чиглэсэн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3, 62 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.	Сургалт зохион байгуулах	24000	4	96000

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	46.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагыг дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;	24000	4	96000
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	48.1.5.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;	-Үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт тодорхойлох	24000	4	96000
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	49.1.3.сэтгэц-нийгмийн сэргээн засах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээ авах:	-Мэргэжилтэн бэлтгэх	48000	4	192000
Тагнуулын байгууллага	51.1.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;	-Орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах	48000	4	192000

Цагдаагийн байгууллага	52.2.Цагдаагийн байгууллага дэргэдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг судлан тогтоох, тодорхойлох, шинжилгээ хийх лабораторитой байна. 67.2.Энэ хуулийн 67.1.1, 67.1.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг цагдаагийн төв байгууллага хариуцаж, хяналт тавина. 67.3.Энэ хуулийн 67.1.3- т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг Донтох эмгэгийг нөхөн сэргээх төв хариуцаж, хяналт тавина.	-Шинжилгээ хийх лаборатори бий болгох	48000	12	576000
Хил хамгаалах байгууллага	53.1.3.хил орчмын нутаг дэвсгэрт тогтоогдсон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг эрх бүхий байгууллагатай хамтран устгах арга хэмжээ авах;	-Устгах арга хэмжээ авах	24000	1	24000
Гаалийн байгууллага	54.1.2.Монгол Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг зөвшөөрөл, холбогдох баримт бичигтэй тулган шалгах, бүртгэх, газар дээр нь дээж авч, шинжилгээнд хамруулах; 54.1.4.мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг олж илрүүлэх, таньж мэдэх зориулалт бүхий орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулах;	-Шинжилгээнд хамруулах; -Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ашиглах; -Алба хаагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах тогтмол сургалт зохион байгуулах	24000	4	96000

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	51.1.3.алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах;	-Алба хаагчийн мэдлэг ур чадварыг сайжруулах тогтмол сургалт зохион байгуулах; -Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ашиглах;	48000	4	192000
Нийт					2,064,000

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 х 8) 1600 ажлын цаг буюу (1600 х 60) 96.000 минут ажиллана.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	24000	96000	0.25
Үндэсний хороо	96000	96000	1
Гаалийн байгууллага	96000	96000	1
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	288000	96000	3
Аймаг нийслэл дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага	96000	96000	1
Донтох нийгмийн сэргээн засах төв	96000	96000	1
Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	96000	96000	1
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	96000	96000	1



Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	96000	96000	1
Тагнуулын байгууллага	192000	96000	2
Цагдаагийн байгууллага	192000	96000	2
Хил хамгаалах байгууллага	576000	96000	6
Гаалийн байгууллага	24000	96000	0.25
Нийт			20.5

1.3 Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Хуулийн төслийн 52.2.-т Цагдаагийн байгууллага дэргэдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг судлан тогтоох, тодорхойлох, шинжилгээ хийх лабораторитой байна. Гэсний дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторид шаардлагатай бүтэц орон тоо, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн зардлыг тооцов.

Хуулийн төсөлд улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 2,050,000², жилд 24,600,000 гэж тооцон, тагнуул, цагдаагийн байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 1,682,917³, жилд 20,195,004 гэж тооцлоо.

Энэ зардал дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	0.25	24,600,000	6150000

² Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342347221&showType=1>

³ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342407681&showType=1>



Үндэсний хороо	1	24,600,000	24600000
Гаалийн байгууллага	1	20,195,004	20195004
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3	24,600,000	73800000
Аймаг нийслэл дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага	1	24,600,000	24600000
Донтох нийгмийн сэргээн засах төв	1	24,600,000	24600000
Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1	24,600,000	24600000
Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1	24,600,000	24600000
Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	1	24,600,000	24600000
Тагнуулын байгууллага	2	20,195,004	40390008
Цагдаагийн байгууллага	2	20,195,004	40390008
Хил хамгаалах байгууллага	6	20,195,004	121170024
Гаалийн байгууллага	0.25	20,195,004	5048751
Нийт			454,743,79 5

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

